

Маргааны товч

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-1/476 дугаартай "... "ХААН банк" ХХК /хуучнаар/-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч "Эйч Эс холдингс" ХК-ийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулсан тухай бүртгэлийг хийсэн ..." талаарх албан бичгийг тус банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ариунтулгад хүргүүлжээ.

Нэхэмжлэгчээс дээрх албан бичиг болон бүртгэлийг хүчингүй болгуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргаж, "... манай компани нэгдмэл сонирхол бүхий этгээдийн хамтаар ХААН банкны 25.31 хувийн хувьцааг эзэмшдэг. Монголбанкны хуульд нийцээгүй шийдвэрийн улмаас бид Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкны дүрэм журмыг үл тоомсорлодог, хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны байх, эх үүсвэр, эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь эргэлзээ бүхий этгээдтэй Монгол Улсын нөлөө бүхий системийн банкиг удирдах нь бизнесийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж байна, ... ХААН банк болоод түүний хувьцаа эзэмшигч "Таванбогд трейд" ХХК-ийн хувьд хувьцааны үнэ цэнэ, хувьцаа эзэмшигчийн авах ноогдол ашиг буурах өндөр эрсдэл үүсгэж байгаа нь бидний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг шууд хөндөж байна. ХААН банкны зүгээс "Эйч Эс холдингс" ХК-ийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулахыг хүссэн хүсэлтийг Монголбанкинд гаргаж байгаагүй болох нь баримтуудаар нотлогдож байгаа, тухайн албан бичиг нь агуулгын хувьд зөрчилтэй, ... мэдээлэл дамжуулах тухай бичгийг Хаан банкны зөвшөөрөл хүссэн хүсэлт мэтээр гуйвуулан тайлбарласан, ... банкиг төлөөлөх эрх бүхий этгээдээс хүсэлтээ хуульд заасан журмын дагуу гаргаагүй байхад Монголбанкны Ерөнхийлөгч бүртгэл хийж, энэ талаараа банкинд мэдэгдэж байгаа нь холбогдох хууль, журмын зохицуулалтыг зөрчсөн, ..." гэж;

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс "... "ХААН банк" ХК-аас зөвшөөрөл хүсэж Монголбанканд ирүүлсэн холбогдох баримтыг шалгахад "Упсилон Инвестмент" ХХН, түүний ерөнхий партнер "Мета капитал" компанийн зүгээс хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, нөлөө бүхий бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны эцсийн өмчлөгчийг тодорхойлсон баримт нь Банкны тухай хуульд заасны дагуу зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэлгүй байсан тул Монголбанкнаас хуульд заасан бүрэн эрхийн дагуу 2022 оны А-1/476 дугаар албан бичгээр "ХААН банк" ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч "Эйч Эс холдингс" ХК-ийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулах тухай холбогдох зөвшөөрлийг олгосон. Нэхэмжлэлийн шаардлагад дурдсан зөвшөөрөл авсан холбогдох этгээдүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлохоор бүрдүүлсэн баримт бичгүүд нь хууль ёсны байх шаардлагыг хангаагүй нөхцөл байдал шинээр илэрсэн тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу холбогдох арга хэмжээг Монголбанкнаас авч ажиллах бөгөөд нэхэмжлэгчийн энэ талаар дурдсан үйл баримт, зөрчил тогтоогдоогүй ..." гэх агуулгаар тус тус маргасан.